



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453317, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn
--------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.12 № УВА-2026/155/НА-СТА-ТЦЗ
танай _____ -ны № _____ -т

ОЙРАД ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН
ТЕАТРЫН ДАРГА
Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050195

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>424,662,667.10</u>	<u>436,842,603.50</u>
33	АВЛАГА	33,684,467.60	31,043,204.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,064,931.32	350,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	29,220,600.00	30,265,600.00
335	Бусад авлага	2,398,936.28	427,604.00
3351	Байгууллагаас авах авлага	2,398,936.28	427,604.00
35	БАРАА МАТЕРИАЛ	390,978,199.50	405,799,399.50
351	Түүхий эд материал	6,790,900.00	10,392,900.00
35110	Тусгай зориулалттай материал	6,790,900.00	10,392,900.00
354	Хангамжийн материал	384,187,299.50	395,406,499.50
35410	Бичиг хэргийн материал	70,000.00	115,000.00
35420	Аж ахуйн материал	14,183,710.00	22,842,910.00
35470	Бусад хангамжийн материал	369,933,589.50	372,448,589.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>577,559,074.34</u>	<u>16,124,217,860.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	577,559,074.34	16,124,217,860.08
392	Биет хөрөнгө	269,340,161.66	15,920,560,197.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	183,003,778.44	10,225,850,375.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,134,653.50	280,465.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,840,000.00	122,840,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-132,840,000.00	-122,840,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,537,256.08	489,021,871.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-132,263,533.24	-152,276,312.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,729,769.86	54,599,669.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,837,344.93	-51,071,830.69
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	00.00	380,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	86,342,552.50	5,046,044,611.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-63,037,663.55	-71,888,652.32
393	Биет бус хөрөнгө	308,218,912.68	203,657,662.40
39301	Програм хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.00	-385,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	318,431,700.00	214,411,700.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-10,212,787.32	-10,754,037.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,002,221,741.44</u>	<u>16,561,060,463.58</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,807,000.00</u>	<u>27,089,002.07</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,807,000.00	27,089,002.07
413	Өглөг	1,807,000.00	27,089,002.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	14,548,373.07
4136	Бусад өглөг	1,807,000.00	12,540,629.00
41361	Байгууллагад төлөх өглөг	47,000.00	3,330,029.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,760,000.00	9,210,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,000,414,741.44</u>	<u>16,533,971,461.51</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	1,000,414,741.44	16,533,971,461.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	747,992,029.30	747,992,029.30
51101	Өмч: - төрийн	747,992,029.30	747,992,029.30
512	Хуримтлагдсан үр дүн	-38,170,036.10	15,785,793,024.23
51210	Өмнөх үеийн үр дүн	-38,170,036.10	252,236,304.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,533,556,720.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	290,592,748.24	186,407.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,002,221,741.44</u>	<u>16,561,060,463.58</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,095,970,064.18	19,422,994,749.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419,179,125.00	15,906,963,749.00
120	Нийтлэг татварын бус орлого	419,179,125.00	15,906,963,749.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	419,179,125.00	15,906,963,749.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,055,950.00	77,596,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	260,000,000.00	10,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,123,175.00	15,819,367,749.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,676,790,939.18	3,516,031,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,731,200.00	842,424,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,731,200.00	842,424,400.00
1330	Төсвийн захирагчдаас	2,580,059,739.18	2,673,606,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,580,059,739.18	2,673,606,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,936,795,401.47	3,617,689,369.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,936,795,401.47	3,617,689,369.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,855,042,183.41	3,145,523,006.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,099,293,803.97	2,226,550,951.43
210101	Үндсэн цалин	1,435,157,657.80	1,362,370,309.89
210102	Нэмэгдэл	447,322,747.17	628,764,934.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,077,889.00	101,445,517.05
210104	Урамшуулал	164,735,510.00	133,970,190.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,794,758.22	280,472,375.60
210201	Тэтгэврийн даатгал	181,734,916.90	190,374,975.25
210202	Тэтгэмжийн даатгал	19,565,034.54	22,681,304.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,311,551.90	11,793,854.45
210204	Ажилгүйдлийн даатгал	9,376,823.11	11,124,448.23
210205	Эрүүл мэндийн даатгал	40,806,431.77	44,497,792.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,851,221.37	467,940,987.70
210301	Гэрэл, цахилгаан	6,391,911.46	19,118,127.80
210302	Түлш, халаалт	81,117,967.91	433,155,614.90

210303	Цэвэр, бохир ус	1,341,342.00	15,667,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,063,010.16	24,892,888.00
210401	Бичиг хэрэг	4,586,482.00	1,911,100.00
210402	Тээвэр, шатахуун	38,543,845.00	6,262,122.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,412,583.16	2,673,066.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,122,100.00	13,446,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,085,000.00	18,064,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,552,500.00
210604	Урсгал засвар	5,085,000.00	14,512,000.00
2107	Томилолт, зочны зардал	45,062,000.00	6,610,000.00
210702	Дотоод албан томилолт	45,062,000.00	6,610,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,631,250.00	68,108,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,267,650.00	65,151,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	168,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	179,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,153,000.00	89,000.00
210807	Газрын төлбөр	3,051,600.00	1,980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,261,139.69	52,882,453.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,767,950.00	22,242,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,422,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,071,189.69	30,639,503.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,753,218.06	472,166,362.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,444,000.00	102,194,683.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,660,000.00	11,277,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	68,990,483.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,952,000.00	17,808,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,832,000.00	4,118,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,014,239.43	3,891,667.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,014,239.43	3,891,667.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,294,978.63	366,080,012.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,294,978.63	366,080,012.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>159,174,662.71</u>	<u>15,805,305,379.40</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	271,748,659.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	271,748,659.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-271,748,659.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>159,174,662.71</u>	<u>15,533,556,720.07</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,060,966,889.18</u>	<u>3,602,582,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	384,175,950.00	86,551,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	384,175,950.00	86,551,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	384,175,950.00	86,551,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,175,950.00	76,551,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	260,000,000.00	10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,676,790,939.18	3,516,031,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,731,200.00	842,424,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,731,200.00	842,424,400.00
1330	Төсвийн захирагчдаас	2,580,059,739.18	2,673,606,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,580,059,739.18	2,673,606,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,077,536,719.29</u>	<u>3,602,582,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,077,536,719.29	3,602,582,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,999,863,501.23	3,130,000,637.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,099,874,301.70	2,218,684,617.50
210101	Үндсэн цалин	1,278,330,552.04	1,278,314,870.29
210102	Нэмэгдэл	578,197,649.66	724,090,692.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,420,000.00	72,211,301.04
210104	Урамшуулал	165,926,100.00	144,067,753.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	264,631,900.00	269,959,072.86
210201	Тэтгэврийн даатгал	179,949,600.00	184,024,931.62
210202	Тэтгэмжийн даатгал	21,170,600.00	21,530,265.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,663,006.14	10,955,664.26
210204	Ажилгүйдлийн даатгал	10,507,593.86	10,689,642.39
210205	Эрүүл мэндийн даатгал	42,341,100.00	42,758,569.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,851,221.37	467,940,987.70
210301	Гэрэл, цахилгаан	6,391,911.46	19,118,127.80
210302	Түлш, халаалт	81,117,967.91	433,155,614.90
210303	Цэвэр, бохир ус	1,341,342.00	15,667,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,003,378.16	22,976,809.00
210401	Бичиг хэрэг	4,546,200.00	1,690,950.00
210402	Тээвэр, шатахуун	38,543,845.00	6,223,159.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,412,583.16	2,541,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,102,750.00	11,921,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,569,000.00	49,644,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,894,200.00	31,636,800.00
210602	Тавилга	589,800.00	2,419,900.00
210604	Урсгал засвар	5,085,000.00	15,587,900.00
2107	Томилолт, зочны зардал	37,040,000.00	6,610,000.00
210702	Дотоод албан томилолт	37,040,000.00	6,610,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	226,819,100.00	69,781,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,042,500.00	66,367,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	440,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	168,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	212,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,333,000.00	826,000.00
210807	Газрын төлбөр	3,051,600.00	1,980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,074,600.00	24,403,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,652,600.00	24,403,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,422,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,673,218.06	472,581,362.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,364,000.00	102,609,683.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,660,000.00	11,577,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	68,690,483.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,952,000.00	17,808,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,752,000.00	4,533,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,014,239.43	3,891,667.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,014,239.43	3,891,667.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,294,978.63	366,080,012.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,294,978.63	366,080,012.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-16,569,830.11</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-16,569,830.11	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,569,830.11	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	442,274,425.15	141,209,632.40	-280,548,577.96	302,935,479.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	442,274,425.15	141,209,632.40	-280,548,577.96	302,935,479.59
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00

Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,621,601.27	-6,621,601.27
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	747,992,029.30	290,592,748.24	-38,170,036.10	1,000,414,741.44
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	747,992,029.30	290,592,748.24	-38,170,036.10	1,000,414,741.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	290,406,340.26	290,406,340.26
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	747,992,029.30	290,592,748.24	252,236,304.16	1,290,821,081.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	290,406,340.26	00.00	-290,406,340.26
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,533,556,720.07	15,533,556,720.07
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	747,992,029.30	186,407.98	15,785,793,024.23	16,533,971,461.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,856,007,600.00	2,756,265,932.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,856,007,600.00	2,756,265,932.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,751,792,300.00	2,653,656,249.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,231,942,900.00	2,218,684,617.50
210101	Үндсэн цалин	1,297,581,300.00	1,278,314,870.29
210102	Нэмэгдэл	716,925,000.00	724,090,692.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,667,000.00	72,211,301.04
210104	Урамшуулал	143,769,600.00	144,067,753.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,992,900.00	269,959,072.86
210201	Тэтгэврийн даатгал	190,126,800.00	184,024,931.62
210202	Тэтгэмжийн даатгал	22,216,500.00	21,530,265.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,108,300.00	10,955,664.26
210204	Ажилгүйдлийн даатгал	11,108,300.00	10,689,642.39
210205	Эрүүл мэндийн даатгал	44,433,000.00	42,758,569.52
2104	Хангамж, бараа материалын зардал	25,265,700.00	22,976,809.00
210401	Бичиг хэрэг	1,384,400.00	1,690,950.00
210402	Тээвэр, шатахуун	11,689,400.00	6,223,159.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,113,500.00	2,541,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,728,400.00	11,921,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,262,600.00	41,241,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,373,600.00	31,636,800.00
210602	Тавилга	1,889,000.00	2,419,900.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,184,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,000,000.00	6,610,000.00
210702	Дотоод албан томилолт	7,000,000.00	6,610,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,113,000.00	69,781,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,588,000.00	66,367,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	286,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	168,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	877,000.00	826,000.00
210807	Газрын төлбөр	3,050,000.00	1,980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25215200.00	24403300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,155,200.00	24,403,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104215300.00	102609683.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,215,300.00	102,609,683.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,577,600.00	11,577,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,721,000.00	68,690,483.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,808,000.00	17,808,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,108,700.00	4,533,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	765,952,300.00	2,756,265,932.36
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	617,477,900.00	2,669,714,932.36
131001	Улсын төсвөөс санхүүжих	617,477,900.00	2,669,714,932.36
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	148,474,400.00	86,551,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	138,474,400.00	76,551,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,000,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	75.00	75.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	67.00	67.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	842,424,400.00	476,344,387.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	842,424,400.00	476,344,387.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,424,400.00	476,344,387.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,572,800.00	8,403,400.00
210604	Урсгал засвар	8,572,800.00	8,403,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	842,424,400.00	476,344,387.70
132001	Орон нутгийн төсвөөс	842,424,400.00	476,344,387.70
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	842,424,400.00	476,344,387.70
122002	Хандив тусламж /гадаад/		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	75.00	75.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	67.00	67.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ойрад хөгжимт жүжгийн театр нь Баруун Монголын олон ястны урлагийн баялаг өв санг орчин үеийн урлаг соёлын ололттой нягт уялдуулан өөрийн өнгө төрх бүхий мэргэжлийн театр байх явдал мөн гэсэн эрхэм зорилгын дор доорх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Ойрадын олон үндэстэн ястны ардын урлагийн өв санг мэргэжлийн өндөр түвшинд баяжуулан театрын урын сангийн өөрийн гэсэн ялгарах бодлоготой байна. Ардын урлагийн өв санг фондлох, архивлах, шинжлэх ухааны эргэлтэд оруулах, уран бүтээлийн эргэлтэд оруулах, олон үндэстэн ястны ардын урлагийн мартагдах шахсан төрлүүдийг судлах, сурвалжлах, өөрийн урын сангаа шинэ бүтээлээр баяжуулах зорилготой.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ойрад хөгжимт жүжгийн театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ойрад хөгжимт жүжгийн театрын тайлант оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,558,838,7 мянган төгрөгөөр буюу 1,552.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	33,684.7	31,043.2	2,641.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	390,978.2	405,799.4	-14,821.2
Үндсэн хөрөнгө	577,559.1	16,124,217.9	-15,546,658.8
Нийт хөрөнгө	1,002,221.7	16,561,060.5	-15,558,838.7
Өр төлбөр	1,807.0	27,089.0	-25,282.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,000,414.7	16,533,971.5	-15,533,556.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,002,221.7	16,561,060.5	-15,558,838.7

Бараа материалын дансны үлдэгдэл 405,799.4 мянган төгрөг болж 14,821.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын болон аж ахуй материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 16,124,217.9 мянган төгрөг болж 15,546,658.8 мянган төгрөгөөр өссөн нь 15,815,387.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 31,043.2 мянган төгрөг болж 2,641.3 мянган төгрөгөөр буурсан нь зээлээр борлуулсан билетийн авлага буурсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 27,089.0 мянган төгрөг болж 25,282.0 мянган төгрөгөөр өсөхөд 95,850.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу бүрдсэнээс хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүссэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,533,971.5 мянган төгрөг болж 15,533,556.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,265,653.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 2,568,277.3 мянган төгрөгөөр бууруулан 2,697,376.3 мянган төгрөгөөр анх баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анх батлагдсан төсвийг 158,631.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,856,0077.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,756,265.9 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс 33,926.6 мянган төгрөгөөр дутуу ирсэн, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогыг 61,923.4 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлж, 3,891.6 мянган төгрөг хэмнэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,231,942.9	2,218,684.6	13,258.3	99.4%
2	71702-Соёл урлаг 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	278,992.9	269,959.1	9,033.8	96.8%
3	71702-Соёл урлаг 80214 -Уран бүтээл хийлгэх	30,000.0	20,000.0	10,000.0	66.6%
4	71702- Соёл урлаг 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	86,529.0	86,498.5	30.5	99.9%
5	81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	77,184.0	76,415.3	768.7	99%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ойрад хөгжимт жүжгийн театр орон нутгийн төсвөөс 842,424.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 476,344.4 мянган төгрөгийг зарцуулж 366,080.0 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжтай холбоотой гарсан зардал	737.0	Санхүүгийн программ эрхийн сунгалт
2	Унаа хоолны зардлын гүйцэтгэл	72,211.3	Ойрад ХЖТ-ын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу өдрийн 4.0-10.0 мянган төгрөг олгодог
3	Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал		Сургалт семинар, хурал зөвлөгөөнтэй холбоотой зардал гараагүй
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	9,500.0	ОХУ руу ОУ-ын Хөөмийчдийн уралдаанд оролцсон уран бүтээлчдийн байр, тээврийн хөлс
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал		Төрд учирсан хохирол барагдуулахтай холбоотой зардал гараагүй
6	Байгууллагын орон тоо	68	2025 онд орон тооны цомхотгол хийж 9% буюу 7 оронтой бууруулсан
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	3,700.0	Увсчууд сайт болон МБСТВ ХХК-тай хамтран ажилласан

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ойрад хөгжимт жүжгийн театр тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ойрад хөгжимт жүжгийн театр тайлант онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,936,795.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 29,367.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 23,494.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,617,698.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 36,176.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 28,941.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ойрад хөгжимт жүжгийн театрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2025 оны А/26 дугаар тушаалаар бэлэг дурсгалын зүйлд 1,455.9 мянган төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ойрад хөгжимт жүжгийн театр нь Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 152,116.6 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 584,434.3 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ойрад хөгжимт жүжгийн театрын нягтлан бодогчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасныг үндэслэн татварын мэргэшсэн зөвлөхийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 40 хувиар олгосон байна. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон эрх зүйн акт байхгүй учраас байгууллага бүрд харилцан адилгүй хувь хэмжээгээр олгож байгааг харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 736,550.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,455.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 737,856.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2025 оны А/12 дугаар тушаалаар бэлэг дурсгалын зүйлд төсвөөс 1,455.9 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Дотоод журамд заасан хугацааг хэтрүүлэн цалинтай чөлөө олгосон байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид байгууллагын дотоод журмын 5.13-т “Ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн, аав, ээж, ах дүү нь Улаанбаатар хот гадаадад эмчилгээнд явах тохиолдолд байгууллагаас дэмжлэг үзүүлж 1 сарын цалинтай чөлөө олгоно” гэж заасныг мөрдөж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 152,116.6 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 584,434.3 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээ шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль, тогтоомж зөрчсөн	2	2,761.4			1	1,455.9	1	1,305.5				
Дүн	2	2,761.4			1	1,455.9	1	1,305.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл байршуулаагүй	1	736,550.9					1	736,550.9
Дүн	1	736,550.9					1	736,550.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	736,550.9					1	736,550.9

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.БАТСУУРЬ/
М.БАТ-АМГАЛАН/
Б.АВИРМЭД/

2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр